

ТӨРИЙН САНГИЙН БОЛОН МӨНГӨ ЗЭЭЛИЙН БОДЛОГО



Багш Д.Уранцэцэг II улирал.
Email: D.Urantsetseg@must.edu.mn

ТУЛГУУР ОЙЛГОЛТ

- Татвар-хуулийн дагуу, тогтоогдсон хэмжээгээр бүх хүн, хуулийн этгээдээс төрд заавал төлөх, буцалтгүй шинжтэй хураамж юм.
- Бонд-тодорхой хэмжээний мөнгийг тогтоосон хугацааны дараа, зохих хүүтэй эргүүлэн төлөхийн баталгаа болох үнэт цаас юм.
- Төрийн сангийн бодлого-нийт эрэлтийг нэмэгдүүлэх зорилгоор улсын орлого, зарлагыг өөрчлөх бодлого юм.
- Төрийн мөнгө зээлийн бодлого-нийт эрэлтийг нэмэгдүүлэх зорилгоор мөнгөний хэмжээ болон зээлийн хүүд нөлөөлөх бодлого юм.

ДАСГАЛ-1

Нийт эрэлтийн бүрэлдэхүүн хэсгийг нөхөж бичих

д/д	Тэмдэглэгээ	Хэрэглэгчийн зардлын бүрэлдэхүүн	Тайлбар
1	C	Өрхийн хэрэглээний зардал	
2	I	?	
3	G	?	
4	X	?	
		Нийт эрэлт = C+I+G+X	

ТӨРИЙН МӨНГӨ ЗЭЭЛИЙН БОДЛОГО

Нийт эрэлтийг
нэмэгдүүлэх



Зээлийн хүүг
бууруулах




Гүйлгээнд байх
мөнгийг ихэсгэх



Засгийн газар бонд
гаргах



Татварын төрөл



- **Улсын төсөв** гэдэг нь нийгэм, эдийн засгийн зорилгыг хэрэгжүүлэх хэрэгсэл бөгөөд улсын мөнгөн хөрөнгийн төвлөрсөн хуримтлалыг бий болгож хуваарилж буй явдлыг хэлнэ. Өөрөөр хэлбэл парламентаас баталж, Засгийн газар бүрдүүлэн зарцуулдаг мөнгөн хөрөнгийг хэлдэг.
- Улсын төсвийн нийт орлогыг дотор нь:
 1. Урсгал орлого
 2. Тусламжийн орлого гэж ангилдаг.
- Улсын төсвийн урсгал орлого - цэвэр дотоод эх үүсвэрээс бүрдэх бөгөөд
 - а. татварын орлого
 - б. татварын бус орлого гэж ангилдаг. Улсын төсвийн тусламжийн орлого - гадаад орон, олон улсын байгууллагын буцалтгүй тусламжийн орлогоос бүрддэг.
- Улсын төсвийн нийт зарлагыг
 1. Урсгал зардал
 2. Хөрөнгийн зардал
 3. Эргэж төлөгдөх цэвэр зээл гэж ангилдаг.

САНГИЙН БОДЛОГО




Макро эдийн засгийн үндсэн зорилтууд болох урт хугацааны эдийн засгийн тогтвортой өсөлтийг бий болгох, инфляцийг тогтворжуулах болон ажилгүйдлийг бууруулах зэрэг эдийн засгийн хөгжлийн тулгуур асуудлуудыг шийдвэрлэхэд чиглэсэн төрийн үйл ажиллагаа юм.



Нийт эрэлтийг нэмэгдүүлэх зорилгоор улсын орлого, зарлагыг өөрчлөх бодлогыг **төрийн сангийн бодлого гэнэ.**

- Улсын зардлыг нэмэгдүүлэх (Бонд гаргах)
- Татварыг багасгах





**САНГИЙН БОДЛОГЫГ
ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭРЭГСЭЛ**



Үйл ажиллагаа 4.2


Хуудас- 108



А.Лафферийн муруй

Татварын нэг шатлалын систем юм.

Тэнцүү татварын хувь 12-19 хувь байх нь тохиромжтой гэж үздэг.





Нийт эрэлтийг нэмэгдүүлэх зорилгоор мөнгөний
хэмжээ болон зээлийн хүүд нөлөөлөх бодлогыг
төрийн мөнгө, зээлийн бодлого гэнэ.



Арга зам:

- Зээлийн хүүг бууруулах
- Гүйлгээнд байх мөнгөний хэмжээг нэмэгдүүлэх
- Засгийн газар бонд гаргах



ТӨВ БАНКНЫ ҮНДСЭН ЗОРИЛГО

- Үнийн тогтвортой байдлыг (инфляци) хангах юм.
- Төв банк нь өөрийн үндсэн зорилтын хүрээнд санхүүгийн зах зээл, банкны тогтолцооны тогтвортой байдлыг хангах замаар үндэсний эдийн засгийн тэнцвэртэй хөгжилд дэмжлэг үзүүлдэг.
- Төв банк нь төрийн мөнгөний бодлогыг өөрийн мөнгөний нийлүүлэлтэнд тавих хяналтын үүргээрээ дамжуулан хэрэгжүүлдэг.
- Төв банкны зорилтыг хэрэгжүүлэх болон эдийн засгийн тогтворжилтонд нөлөөлөх гол хүчин зүйл нь мөнгөний нийлүүлэлт болдог.

МӨНГӨНИЙ ХАТУУ, ЗӨӨЛӨН БОДЛОГО

МӨНГӨНИЙ ХАТУУ БОДЛОГО

Эдийн засгийн мөчлөгийн сэргэлтийн болон оргил үед үнийн ерөнхий түвшний өсөлтийг бууруулах, урьдчилан сэргийлэх, мөнгөний нийлүүлэлтийг бууруулах зорилгоор мөнгөний хатуу бодлогыг авч хэрэгжүүлдэг. (Жишээ нь: Бодлогын хүүг өсгөх)

МӨНГӨНИЙ ЗӨӨЛӨН БОДЛОГО

Эдийн засгийн уналтын үед ажилгүйдлийг бууруулж, эдийн засгийн өсөлтийг эрчимжүүлэх зорилгоор мөнгөний нийлүүлэлтийг өсгөн, мөнгөний зөөлөн бодлогыг авч хэрэгжүүлдэг. (Жишээ нь: Бодлогын хүүг бууруулах)





Монгол банкны мөнгө, зээлийн жилийн өсөлт
2015-2022 оны 7 сар хүртэл

<https://stat.mongolbank.mn/?r=144>



Төрийн эдийн засаг зайлшгүй болохыг нотолсон, няцаасан үндэслэлийг тайлбарлах

Фридрих фон Хайек (1899-1992).



Хайекын сонирхдог эдийн засгийн асуудлуудын хүрээ маш өргөн бөгөөд түүний боловсруулсан эдийн засгийн онолууд нь нийтээр хүлээн зөвшөөрсөн үзэл бодолтой байнга зөрчилддөг. Тухайлбал, Хайек гүйлгээнд байгаа мөнгөний хэмжээ болон үнийн түвшний хооронд шууд холбоо байхгүй гэдгийг баталсны зэрэгцээ зах зээлийн эдийн засаг дахь төрийн идэвхтэй оролцоо нь түүнд зөвхөн хор учруулна гэж үздэг. Хайек эдийн засгийн амьдрал, логик, ёс зүй болон социализмын шинжлэх ухааны үндэслэлийг бүх талаас нь судалж үзээд социализмыг аль талаас нь авч үзсэн ч маш алдаатай байсан гэдгийг нотолж байжээ. Эдийн засгийн салбарт оруулсан хувь нэмрийг үнэлэн 1974 онд түүнд Нобелийн шагнал олгожээ.

Джон Мейнард Кейнс (1883-1945).



Кейнсийг эдийн засгийн шинжлэх ухаанд хувьсгал хийсэн хүн гэж үздэг. Тэрээр сонгодог уран зохиол, хөгжим, спортоор хичээллэхийн зэрэгцээ хөрөнгийн бирж дээр тоглож асар их амжилт олж байжээ. Кейнс зах зээлийн тогтолцоо нь эдийн засгийн уналтаас өөрийгөө аварч чадахгүй гэдгийг баталж төрийн оролцоотой нийт эрэлтийг нэмэгдүүлэх замаар энэ зорилтыг шийдэх ёстой гэж үзжээ. 1930 аад оны эхээр барууны орнуудыг хамарсан хүчтэй бөгөөд сунжирсан эдийн засгийн уналт нь Кейнсийн дүгнэлтийг нэг ёсондоо баталжээ. Кейнсийн онол нь макроэдийн засгийн онолын цаашдын хөгжил болон барууны орнуудын төрийн эдийн засгийн бодлогод маш их нөлөө үзүүлжээ. Түүнчлэн Кейнс мөнгө болон банкны талаарх агуу онолч төдийгүй онолыг хэрэгжүүлэгч юм. Түүний зөвлөгөөгөөр Англи болон бусад орнуудад банкны шинэчлэлүүд хийгджээ. Эх орныхоо өмнө байгуулсан гавьяаг нь үнэлэн түүнд "Лорд" зэрэг олгожээ.



Гэрийн даалгавар

Сурах бичиг-114 хуудас

